

ТАЙЛБАР БИЧИГ

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороо Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн 98 магистраль, Цэвэрлэхийн салаа шугамын гадна дулааны шугамын ажлын зургийг хийж гүйцэтгэхдээ дараах зүйлсийг үндэслэл болгов. Үүнд:

- 2018 оны ЧБДС ТӨХК-ийн "Техникийн бодлогын бичиг баримт"
- 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 2019 онд их засвар, хөрөнгө оруулалтаар солих шаардлагатай шугамын талаар хийсэн хурлын шийдвэр

Зураг төслийг дараах норм дүрмийг баримталж боловсруулав:

- БНБД 23-01-09 Барилгад хэрэглэгдэх уур амьсгал, ба геофизикийн үзүүлэлтүүд
- БНБД 41-02-13 Дулааны сүлжээ
- БНБД 41-04-13 Тоног төхөөрөмж ба дамжуулах хоолойн дулаан тусгаарлалт

Тус шугам нь 1987 онд ашиглалтанд орсон бөгөөд ашиглалтын хугацаа дууссан тул 2019 оны зуны засварын хугацаанд сольж шинэчлэхээр ажлын зураг төслийг төлөвлөв.

ДХ-935-14-р худагт байгаа Хос Корон ХХК нь үл хөдлөх тулгуургүй цэгээс огтолгоо авч БНБД, ТАД-ийг зөрчсөн байгааг үл хөдлөх тулгууртай цэгт шилжүүлж ТАД-ийг хангуулах.

Үл хөдлөх тулгууртай цэгт хэрэглэгчээр стандартын шаардлага хангасан худаг хийлгэж огтолгоог хийнэ.

Улаанбаатар хотын гадна агаарын тооцоот температур -39°C, энэ үеийн сүлжээний усны температур 135/70°C байна.

Ган яндан нь Ст-20, Q345B буюу түүнтэй дүйцэхүйц маркын шулуун оёдолтой эсвэл оёдолгүй, ханын зузаан 9мм доошгүй шинэ ган яндангаар хийх. Огтод, шилжүүлэгний ханын зузаан 9мм доошгүй үйлдвэрийн цутгамал байх. Эрх бүхий байгууллагаар металлийн лабораторийн дүгнэлт гаргуулсан байх. Худаг пүткэ болон сувагт хийгдэх металл хийцүүд (Үл хөдлөх тулгуур, косинка, гүлсах тулгуур) нь ус чийгэнд тэсвэртэй Ст-3, Q255B буюу түүнтэй дүйцэхүйц маркаас доошгүй байх.

Одоо байгаа сильфон компенсаторыг буулгахын өмнө сувгийн аманд шугам шилжилтэнд орохоос хамгаалсан хориг хийж хяналтын инженерт шалгуулсны дараа /фото болон видео хэлбэрээр баталгаажуулах/ шугам огтлох, компенсатор буулгахыг зөвшөөрнө. Компенсаторыг угсрахдаа таслалт хийхэд шилжсэн хэмжээг тооцож таталмыг хяналтын инженерийн удирдлага дор техник ашиглалтын дүрмийн дагуу хэвтээ, босоо тэнхлэгийн хазайлтгүй угсрах. Сувгийн аманд болон сувагт тэгш хэмийн явалтыг хангасан чиглүүлэгч хийх.

Шугам угсралтын ажилд ашиглагдах шинэ хаалтуудыг гүйцэтгэгчид захиалагч хүлээлгэж өгөх ба хуучин хаалтыг буулгаж, шинэ хаалтуудыг ТАД-ийн дагуу босоо, хэвтээ тэнхлэгийн хазайлтгүй угсарна.

Зуны засварын батлагдсан графикт зогсолтын хугацаанаас өмнө гүйцэтгэгч компани газар шорооны ажлыг хийж, сувгийг нээж бэлэн болгосон байх бөгөөд шугамыг тасалснаас хойш хуанлийн 8.. хоногийн хугацаанд хуучин шугамыг буулган шинэ шугамыг монтажлах, шахалт угаалтын ажлыг дүрэн хийж залгахад бэлэн болгоно. Шугам залгасны дараа изоляци, дулаалга, тохижилтын ажлыг ажил гүйцэтгэх графикт заасан хугацаанд гүйцэтгэн актаар ажлыг хүлээлгэж өгнө.

Ажил эхлэхийн өмнө зам талбай болон дусад тохижилтын ажлыг хариуцсан байгууллагуудаас зөвшөөрөл авч, ажил дууссаны дараа нөхөн сэргээлтийг дүрэн хийж хүлээлгэн өгсөн тухай актаар хүлээлцсэн байна.

Газар шорооны ажил эхлэхийн өмнө хотын шугам сүлжээ ашиглалтын дүх байгууллагуудтай зөвшөөрөлцөж дулааны шугамтай огтлолцож байгаа болон ойролцоо оршиж байгаа дүх шугам сүлжээг тэмдэглэж, шаардлагатай үед бие төлөөлөгч байлцуулна.

Цахилгаан, холбооны шугамтай огтлолцож буй дулааны шугамын сувгийн таг хүртэлх газар шорооны ажлыг гараар гүйцэтгэж дулааны шугам, худгийг дулахын өмнө газар шорооны ажлын явцад ил гарсан шугам сүлжээг хамгаалалтанд авч, дүрэн дүтэн дайдыг эзэмшигч нарт нь хүлээлгэж өгнө.

Шинээр хийх дулаан дамжуулах хоолойн үл хөдлөх тулгууруудын металл хийцүүдийг хүчтэгэн засварлах бөгөөд дулааны шугамыг тэвш дотор бетон дэр болон гүлсах тулгуур дээр угсарна.

Гүлсах тулгуурын хоорондын зай нь:

- Хоолойн шулуун хэсэгт: Дү325 - 8 м
- Хоолойн эргэлт орчимд: Дү325 - 4.8 м байна.

Шинээр угсарсан шугам, тоноглолыг хатуу эрдэст, нийлэг уян гэх мэт нягт сайтай дулаан алдалт хамгийн бага 0.06 Вт/(м·к)-аас ихгүй, нягтрал нь 30-40 кг/м³, ус бага шингээдэг, цахилгааны өндөр эсэргүүцэлтэй, бат бөх чанартай, галд шатдаггүй дулаалгын материалаар техник ашиглалтын дүрмийн шаардлагын дагуу дулаална. анартай, галд шатдаггүй дулаалгын материалаар техник ашиглалтын дүрмийн шаардлагын дагуу дулаална. Мөн дулаалгын материал хоорондын зай завсрыг зориулалтын дулаан алдагдалгүй материалаар дитүүмжилэн гадуур нь ус чийг нэвтрүүлэхгүй, механик үйлчлэлээс хамгаалах материалаар бүрж зориулалтын будгаар будна. Худаг, пүткэ, Павильон доторх шугам тоноглолыг эх оронд үйлдвэрлэсэн дотоодын дүтээгдэхүүн эрдэс/чулуун/ хөвөн дулаалгаар хийж механик үйлчлэлд тэсвэртэй матрериалаар бүрж зориулалтын будгаар будна.

Хоолойг угсрахын өмнө хоолойн дотор талд хуримтлагдсан шороо хогийг дүрэн цэвэрлэх ба дулаалахын өмнө хоолойн гадна талд наалдсан шороо тоос болон бий болсон зэвийг сайтар цэвэрлэж ээврэлтээс хамгаалах лаван түрхлэгийг 2 үе давхарлаж түрхэн, ухалт хийн сувгийг сөхөж нээх үед шаардлага хангахгүй болсон сувгийн таг, хучилтыг гүйцээж нөхөж хийх.


Угсралтын ажлыг барилгын норм ба дүрмийн дагуу хийж, техник ашиглалтын дүрмийг чанд сахих зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Угсралтын ажил хийж гүйцэтгэсний дараа захиалагчийн хяналтын инженерийг байлцуулан гагнуурын оёдлыг эрх бүхий байгууллагаар шалгуулах ба шугам тоноглолыг 25 ата-аас багагүй даралтаар шахаж шалгах ба угаалт хийж актаар хүлээлгэн өгнө.

ЗУРГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Марк	Зургийн нэр зориулалт	Тайлбар
1	2	3	4
1	12	Тайлбар бичиг, Орчны тойм	ГДГ-1
2	12	Гадна дулааны шугамын байгуулалт	ГДГ-2
3	12	Хоолойн угсралтын тойм, Материалын нэгдсэн түүвэр	ГДГ-3
4	12	1-р цэгийн 935-13-р дулааны худгийн байгуулалт	ГДГ-4
5	12	1-р цэгийн 935-13-р дулааны худгийн огтлол	ГДГ-5
6	12	3-р цэгийн 935-14-р дулааны худгийн байгуулалт	ГДГ-6
7	12	3-р цэгийн 935-14а-р дулааны худгийн байгуулалт	ГДГ-7
8	12	6-р цэгийн 935-15-р дулааны худгийн байгуулалт	ГДГ-8
9	12	2,5-р цэгийн дулааны шугамын 1,2-р зөөлөвчийн байгуулалт	ГДГ-9

ОРЧНЫ ТОЙМ



ДАВТАН ХЭРЭГЛЭГДЭХ ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Серия Г-015-1	Хоолойн үл хөдлөх тулгуур
Серия-991-1 вып-1	Сувгийн эргэлтийн өнцөг
Серия-991-1 вып-1	Цутгамал бетон суваг, сувгийн эргэлтийн өнцөг
Серия-991-1 вып-2	Бетон худаг

	Сонгино хайрхан дүүрэг, 20-р хороо, Оргил худалдааны төвийн хойд талд		
	98 МАГИСТРАЛЬ ДХ-935-14 ДХ-935-15 ХУЛГИЙН ХООРОНД 2Ф300 ММ ГОЛЧТОЙ 275 ХОС МЕТР ШУГАМЫГ ХЭСЭГЧИЛЭН СОЛИХ		
	Тайлбар бичиг, Орчны тойм		Үе шат: А.3
	Инженер	З.Энхболд	ЕГ Шифр:
Гүйцэтгэсэн	Д.Дэлгэрдбаяр	Масштаб:	Огноо: 2018-12
"ЧБДС" ТӨХК	Шалгасан	А.Цогт	ТГ Шифр: УБДС.2018/14
			Зургийн дугаар: ГДГ-1
			Хуудас: 09